

Сангийн сайдын 2013 оны 05  
дугаар сарын 31-ний өдрийн 125  
дугаар тушаалын 1 дүгээр  
хавсралт

## **МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ**

### **ҮНИЙН САНАЛ АВАХ ЖИШИГ БАРИМТ БИЧИГ**

**(ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР БАРАА  
ХУДАЛДАН АВАХАД АШИГЛАНА)**

*2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт орсон.*  
**ХУУЛЬ, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ  
БОДЛОГЫН ГАЗАР**

Улаанбаатар  
2013 он

## ОРШИЛ

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Сангийн яамнаас боловсруулсан энэхүү үнийн санал авах жишиг баримт бичгийг Захиалагч байгууллага 50,000,000 төгрөгөөс доош төсөвт өртөгтэй бараа нийлүүлэх гүйцэтгэчийг харьцуулалтын аргаар сонгох болон шууд гэрээ байгуулах үед мөрдөнө.

Үнийн санал авах жишиг бичиг баримтын заалтуудад зарчмын бус өөрчлөлт оруулж тухайн барааг худалдан авах ажиллагаанд тавигдах шаардлагад нийцүүлбэл зохино. Эдгээр өөрчлөлтийг хийхдээ дараах удирдамжийг дагаж мөрдөнө

1. Үнийн санал авах баримт бичгийг худалдан авах бараа буюу төслийн онцлог байдалд нийцүүлэн энэхүү жишиг баримт бичгийн дагуу бэлтгэнэ.
2. Захиалагч налуу үсгээр хаалтад бичсэн жишээ, зааврын оронд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ, хувь, валют зэргийг бөглөнө. Үнийн санал ирүүлэгчийн бөглөх хэсгийг захиалагч бөглөхгүй орхино.
3. Үнийн санал авах жишиг баримт бичгийн зүүлт/тайлбар болон санамж нь захиалагчид заавар өгөх зорилготой тул үнийн санал авах баримт бичгийг бэлтгэхдээ тэдгээрийг хасна.

Энэхүү тендерийн баримт бичигтэй холбоотой асуулт ирүүлэх, тайлбар эсвэл нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар холбоо барина уу.

Сангийн яамны Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газар

Утас: 267416, 267648

Web: [www.e-procurement.mn](http://www.e-procurement.mn)

**[НАСОС СТАНЦУУДАД УХААЛАГ ЦАХИЛГААНЫ ТООЛУУР] НИЙЛҮҮЛЭХ  
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: *Насос станцуудад ухаалаг цахилгааны тоолуур*

Төслийн дугаар: ИЗ-2020/35

Харьцуулалт/  
гэрээний дугаар: ИЗ-2020/35

Улаанбаатар хот

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

**[Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК]** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **[ДДТ С-728-ийн 4-р бойлерын шинэчлэн солих]**-ийг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **[2020 оны 04-р сарын 15-ны өдрийн 14 цаг 00 минутаас]**-аас өмнө **[[www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)]** хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **[2020 оны 04-р сарын 15]**-ны өдрийн **[14 цаг 30 минут]**<sup>1</sup>-т нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх.<sup>2</sup> Үгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**[Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3-р хороо, Ф.Энгельсийн гудамж,  
“Улаанбаатар Дулааны сүлжээ” ТӨХК-ийн төв байр, Өргөтгөлийн 3 давхар байр  
100 тоот өрөө Утас: 75753047-242, 238 Факс: +976-11-342397.]**

---

<sup>1</sup> Тендерийг хүлээж авах эцсийн хугацааг дууссанаас хойш 1 цагийн дотор байна.

<sup>2</sup> Захиалагч тендер шалгаруулалтад давуу эрхийн зөрүү хэрэглэхгүй бол, энэ өгүүлбэрийг хасч оронд нь “Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй” гэж бичнэ.

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |  |
|---|--|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b> | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.  |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>               | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.<br>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.<br>2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                           | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br>(а) Үнийн санал;<br>(б) Үнийн бол нийлүүлэлтийн хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;<br>(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]   |
| <b>4. Тогтмол үнэ</b>                                   | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.   |
| <b>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</b> | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.<br>5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.  |
| <b>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b>           | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.   |

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> <li>1. Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээний эх хувиас хуулбар ирүүлэх</li> <li>2. Компанийн танилцуулга ирүүлэх</li> <li>3. Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн тодорхойлолт ирүүлэх</li> <li>4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тодорхойлолт ирүүлэх</li> <li>5. Татварын тодорхойлолт ирүүлэх. /тендер нээсэн өдөр, цагт татварын өртэй эсэхийг цахимаар шалгах тул татвар, хураамжаа бүрэн төлсөн байх/</li> </ol> <p>Бусад нэмэлт шаардлага;</p> <ol style="list-style-type: none"> <li>1. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14.1 дүгээр зүйлд (14.1.1 – 14.1.7) заасан нөхцөл байхгүйг албан бичгээр баталгаажуулж ирүүлэх</li> </ol>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:          Байгууллагын хаяг: <b>Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3-р хороо, Ф.Энгельсийн гудамж, “Улаанбаатар Дулааны сүлжээ” ТӨХК-ийн төв байр, Утас: 75753047-242, 238 Факс: +976-11-342397.]</b>  <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим хаягаар ирүүлнэ          Давхар болон ерөөний дугаар: <b>[Өргөтгөлийн 3 давхар байр 100 тоот өрөө]</b>          Огноо: <b>[2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр]</b>          Цаг: <b>[14 цаг 00 минут]</b></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3-р хороо, Ф.Энгельсийн гудамж, “Улаанбаатар Дулааны сүлжээ” ТӨХК-ийн төв байр, Утас: 75753047-242, 238 Факс: +976-11-342397.]</b>          Давхар болон ерөөний дугаар: <b>[Өргөтгөлийн 3 давхар байр 100 тоот өрөө]</b>          Огноо: <b>[2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр]</b>          Цаг: <b>[14 цаг 30 минут]</b></p>
ТӨӨЗ 3.1 а	Жишиг маягтын дагуу үнийн саналыг баталгаажуулж ирүүлэх
ТӨӨЗ 3.1 в	<ol style="list-style-type: none"> <li>1. Сүүлийн [1] /2019/ жилийн санхүүгийн тайлан баталгаажуулж ирүүлэх</li> <li>2. Ижил төстэй ажлын мэдээлэл сүүлийн 2 жилээр /2018, 2019/ жагсаалтаар болон гэрээний хуулбарын хамт ирүүлэх. /ижил төстэй ажилд цахилгааны тоолуур, тоног төхөөрөмжийг ойлгоно/</li> <li>3. Сүүлийн 1 жилийн /2019 он/ борлуулалтын орлого нь төсөвт өртгийн 100% хувиас багагүй байх</li> <li>4. Түргэн хөрвөх хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ нь төсөвт өртгийн 100% хувиас багагүй байх</li> </ol>
ТӨӨЗ 3.1 д	Цахилгаан тоолуур нь техникийн тодорхойлолтод заасан шаардлагуудыг хангасан байх тодорхойлолтыг Монгол хэл дээр баталгаажуулж ирүүлэх.
ТӨӨЗ 3.1 д	Цахилгаан тоолуурын танилцуулга /каталоги/, техникийн үзүүлэлт, үйлдвэрлэсэн газар, сертификатыг Монгол хэл дээр орчуулж баталгаажуулж ирүүлэх
ТӨӨЗ 3.1 д	Тендерт шалгарсан тохиолдолд техникийн шаардлага хангасан Ухаалаг цахилгаан тоолуурыг гэрээнд заасан хугацаанд нийлүүлж хүлээлгэн өгөх баталгааг албан бичгээр ирүүлэх
ТӨӨЗ 3.1 д	Баталгаат хугацаанд /36 сар/ гарсан доголдол, гэмтэл, эвдрэлийг бүрэн хариуцах тухай албан бичиг ирүүлэх
ТӨӨЗ 3.1 д	Монгол улсын загварын туршилтад хамрагдсан байх. Стандарт хэмжил зүйгээр 2020 оноос баталгаажсан гэрчилгээтэй байх. Туршилтын дүгнэлт, гэрчилгээг хуулбарлан ирүүлэх
ТӨӨЗ 7.2	Нийлүүлэх цахилгаан тоолуур нь нийт 31 ширхэг байна

## Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### 1. Барааны тодорхойлолт: [Барааны тодорхойлолтыг доорх хүснэгтээр оруулав.]

#### НАСОС СТАНЦУУДАД УХААЛАГ, УЗЕЛЬ ДАВИЛЬОНД БҮРЭН ЭЛЕКТРОН ЦАХИЛГААН ТООЛУУРЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Д/д	Тоноглолын нэр	Марк	Үзүүлэлт	Тоо ширхэг	Тайлбар
1		DTSD111	Нарийвчлалын ангилал: $\leq 0.1$	20	
			Ажиллах хүчдэл: 3х230/400В		
			Мэдрэх гүйдэл: Номинал гүйдэл 4%-с ихгүй		
			Ажиллах температур: -40C-- +65C		
			Ажиллах давтамжийн хязгаар: 50Гц /+,-5%/		
			Орчны чийгшил: 80%-аас ихгүй		
			Гадны төхөөрөмжтэй холбогдох: RS-485		
			Батерейны ажиллах хугацаа: 10 жилээс багагүй		
			Үйлдвэрийн баталгаат хугацаа: 36 сараас багагүй.		
			Актив, реактив энергийг тоолох боломжтой байх.		
			Тоолуурын програмын хэл: Англи		
2	Тоолуур	DTSD545S	Нарийвчлалын ангилал: $\leq 0.1$	11	Монгол улсын загварын туршилтад хамрагдсан байх. Стандарт хэмжил зүйгээр 2020 оноос баталгаажсан гэрчилгээтэй байх.
			Ажиллах хүчдэл: 3х230/400В		
			Мэдрэх гүйдэл: Номинал гүйдэл 4%-с ихгүй		
			Ажиллах температур: -40C-- +65C		
			Ажиллах давтамжийн хязгаар: 50Гц /+,-5%/		
			Орчны чийгшил: 80%-аас ихгүй		
			Холболтын протокол: DLMS / нэмэлтээр DTL645, IEC, Flag г.м байж болно./		
			Холболтын интерфайс: PLC, GPRS, IR, Ethernet / нэмэлтээр RS485, RS232, USB порт г.м байж болно/		
			Тоолуур болон систем рүү мэдээллийг нууцлалтайгаар дамжуулдаг байх.		
			Тоолууртай PLC технологиор мэдээлэл солилцдог байх.		
			GSM сим картны үүртэй байх.		
			Системийн програм хангамж ажиллаж байгаа сервертэй GPRS технологиор холбогддог байх. /VPN/		
			Батерейны ажиллах хугацаа: 10 жилээс багагүй		
			Үйлдвэрийн баталгаат хугацаа 36 сараас багагүй.		
			Актив, реактив энергийг тоолох боломжтой байх.		
			Тоолуурын програмын хэл: Англи		

2. **Стандарт:** Захиалагч холбогдох стандартыг заана. [ ]-ийг хангасан байна. [ ]-ийг хангасан байна.

3. **Баглаа, боодол:** [ зориулалтын хайрцагт савалсан байна ]

4. **Бараа хүргэх газар:** [Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 4-р хороолол Дулаан дамжуулах төв С-728 ]

5. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**



## БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
<i>Тоолуур DTSD111</i>	<i>Техникийн тодорхойлолт тод заасан</i>	20	<i>Ширхэг</i>	<i>УБДС ТӨХК-ийн төв байр</i>	<i>Гэрээ байгуулагдсанаас хойш 7 хоног</i>	<i>Гэрээ байгуулагдсанаас хойш 10 хоног</i>	
<i>Тоолуур DTSD545S</i>	<i>Техникийн тодорхойлолт тод заасан</i>	11	<i>Ширхэг</i>	<i>УБДС ТӨХК-ийн төв байр</i>	<i>Гэрээ байгуулагдсанаас хойш 7 хоног</i>	<i>Гэрээ байгуулагдсанаас хойш 10 хоног</i>	

**Анхаар: 8-р баганыг зөвхөн тендерт оролцогч бөглөж ирүүлнэ. 1, 2, 3, 4, 5, 6, 7-р багануудыг өөрчилж үл болно.**

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

**Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК**-ний  
гүйцэтгэх захирал Г.Баярсайхан танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |   |
|--|---|
| 1. Шалгах болон турших                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>[3]</b> жил байна.   |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[ГТН-д заасан тоо]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| 10. Үүргээ биелүүлээгүй-ээс гэрээг цуцлах          | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.   |
| 11. Маргааныг шийдвэрлэх                           | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |   |  |
|---|--|
| <b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b>                             | 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]  |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b> | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:<br><ul style="list-style-type: none"><li>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;</li><li>2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;</li><li>3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;</li><li>4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;</li><li>5) барааны гарал үүслийн гэрчилгээ.</li></ul> <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| <b>3. Баталгаат засвар (ГЕН-5)</b>                                  | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.<br><br>[Баталгаат засварын хугацаа <b>36 сар</b> байна]  |
| <b>4. Төлбөр (ГЕН – 7)</b>  | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:<br><br>Гэрээний үнийн дүнгийн <b>[100%]<sup>3</sup></b> хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.   |
| <b>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>4</sup></b>                  | 9.1. Алданги оногдуулах хувь: хугацаа хэтэрсэн хоног тутамд <b>[0,1 хувь]</b><br><br>Алдангийн нийт дүн: <b>[10 хувь]</b>  |

<sup>3</sup> Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

<sup>4</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>5</sup>

**БАТЛАВ.**

**ЗАХИАЛАГЧ**

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**НИЙЛҮҮЛЭГЧ**

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_\_ дугаар сарын \_\_\_\_ -аас \_\_\_\_\_ оны \_\_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>6</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

<sup>5</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>6</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*